

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 10/319

НШУС

2009

ЭХ ОРНЫ ДУУЛААЧ, ИХ ТҮҮХИЙН УЛААЧ ("Хүйлэн хөх замилан", "Бат хаан" номын шүүмж)

Т.Баасансүрэн*

* МОНЦАМЭ агентлагийн захирал, түүхийн ухааны доктор (Ph.D.), шүүмжлэгч

Түлхүүр: ном судар, нийтлэл хүүрнэл, найраглал, бадаг, эргэцүүлэл, баримт.

Ном судар, нийтлэл хүүрнэл олон янз байдаг. Унших гэж хичээгээд цааш явдаггүй, унтуулчих гээд байдаг "бүтээл" бий. Хэдэн жилийн өмнө миний бие телевизийн нэг од болсон эрхмийн нийтлэлийг гүйцээж унших гэж гурвантаа оролдоод бараагүй билээ. Эхний хуудсыг л сөхмөгц урамс бадраад улам улам шунамхайран нэг амьсгалаар гүйцээж болдог бүтээл гэж бас бий. Тэр жил Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дагвын Цахилгааны "Огт оргуйн толь" хэмээх шижиртсэн сайхан бүтээлийг Бээжингээс нисээд Австралийг хөндлөн гулд туулж Шинэ Зеландын нийслэл Веллингтон орон ортол нэг биш бүр хоёронтоо эргүүлж сэтгэл зүрхэнд наран мандсанаа мартаагүй байна. Үнэхээр шимтэй бүтээл байсан тул нутаг буцаж ирээд яаран сууж шүүмж бичиж нийтлүүлсэнсэн.

Дагвын Цахилгаан бол мэргэжлийн зохиолч, сэтгүүлч биш. Нам, төр, олон

нийтийн зүтгэлтэн хүн. Орос хэлний багш. Түүхийн ухааны доктор. Гэтэл мэргэжлийн зохиолч, сэтгүүлчдээс ер дутахааргүй, харин ч тэднийг эвгүй байдалд оруулж ичээмээр жинтэй сайн бүтээл туурвичихсан байж билээ. Яах аргагүй бичиж туурвих төрөлх авъяастай нэгэн. Саяхан "Хүйлэн хөх замилан" хэмээх шүлэг найргийн шинэ номоо хэвлүүлжээ. Сэтгэлдээ тээж явдаг бодол ухаарлын хураа дээжлэн дээжлэн нэрж уншигчиддаа өргөн барьсан нь энэ аж. Номын өмнөтгөлд Монгол Улсын Ардын уран зохиолч Ж.Лхагвасүрэн "Д.Цахилгааны шүлгүүд олон яруу найрагчдын дунд нь биш цээжинд нь байна гэж ам бардам хэлмээр байна"¹ гэж онцлон тэмдэглэсэн нь унших сонирхлыг улам бадраав. Ж.Лхагвасүрэнгийн амнаас хэртэй л бол ийм үг унахгүй. Тэр хэр баргийн найрагчийг тоодог ч хүн биш. Гэтэл Дагвын хүүг тоогоод зогссонгүй ихэд өндрөөр өргөмжлөн үнэлжээ. Энэ бол маш том үнэлгээ. Гэхдээ миний бие хөндлөнгийн хүний үгэнд төдийлөн итгэдэггүй, өөрөө нүдээр харж, чихээр сонсож байж, болж өгвөл өндгөөрөө

үрчин тэмтэрч өр зүрхээрээ туучин
мэдэрч байж сая үнэмшдэг нэгэн тул уг
номын эхний хуудсаас эцсийн хуудсыг
дуустал гүйлгэн харлаа. Ингэхийн учир ч
бас надад байв. Юун хэмээвээс бибээр
Дагвын Цахилгаан бол том гарын
нийтлэлч гэдэгт гүнээ итгэн үнэмшдгээс
бус их гарын шүлэгч гэж хараахан бодож
явсангүй. Иймээс "Хүйлэн хөх замилан"
номыг шимтэн шимтэн уншлаа.

Үзгэн морийг унаж
Үгийн сүргийг хураалаа
Усан тэлмэнг барьж
Уянгын наадамд сойлоо

гэсэн эхний бадаг урамс сэргээж цааш
нь лавшруулбал

Унаар сайтыг шилж
Уншигч тандаа эмээллээ
Ухааны унагыг ногтолж
Утгын зэлэнд эгнүүлээ гэжээ.

Эндээс Дагвын Цахилгаан төрөлх
дүрээрээ харагдах шиг болов. "Огт
оргуйн толь"-ийг тэрбээр чухамхүү
ухааны цараа бяд зааж туурвисан билээ.
Түүний нийтлэл зохиолуудаас уярал,
ухаарал зэрэг зэрэг мэдрэгддэг юм.
Түүнийгээ энэ удаад яруу найргаар
илэрхийлжээ. Бор тархиа саан байж
борви айраг исгэснээ, бодол сэтгэлээ
нэрэн байж бозны ааруул бэлтгэснээ
уншигчиддаа өргөн барьсан байна.

Номын нэгдүгээр хэсэгт гучин шүлэг
найраглал, хоёрдугаар хэсэгт хорин
таван шилмэл шүлэг найраглал жагсжээ.
Бүгд Эх орон, унасан газар ус, нутгийн
хүн ардын гайхамшиг, Монгол орон, мон-
голчуудын өчигдөр, өнөөдөр, маргаа-
шийн тухай эргэцүүлэл багтжээ гэж хэлж
болно. Харь оронд аж төрж, аялж
жуучилж явахдаа бичсэн олон сайхан

таталбарууд нь ч Монгол эх орон,
Монгол зон олонтой холбогдож сүлэгд-
сэн эргэцүүлэл, ухаарлын өнгө аястай
ажээ.

Хотол цагаан хунгийн сүрэг
Хоолой нийлэн дуулж хонолоо
Холын аянд гарахын өмнө
Хонон өнжин чуулж хурлаа
Холбоо цэнхэр нуурыг минь
Ховдол цээжиндээ тэвэрч хонолоо
Холдож салахын өмнө
Хомсхон жаргалыг эдэлж хонолоо
Хоёр нүдний үзүүрт
Хоттой хонь шиг налайж хонолоо

хэмээн "Хунгийн дууль" шүлэгтээ эх нут-
гаа хайрласан монгол хүний сэтгэлийг
нутгийн холбоо цэнхэр нуур, хунгийн
түмэн сүрэгтэй холбон зураглаж гаргаад
түүнийгээ улам чангалж:

Шувуун зудын шамарганд
Малчны гэр дэрвэлзэнэ
Суугуул нутгийн энгээр
Намрын нүүдэл бөртөлзөнө
Суурин хотын бид нар ч
Шувуудыг дагаад өндөлзөнө
Сууц байрны хонгилоор
Зэврүү даагаад хөхөлзөнө

хэмээн төгсгөжээ. Хаана ч байдаггүй
монгол ахуй, монгол сэтгэлгээ, нүүдэлч-
дийн өвөрмөц соёл эндээс нэвт ханхалж
байна.

Зохиолч өөрөө зөн бэлгийн найраг-
лал гэж нэрлэсэн "Хүйлэн хөх замилан"
хэмээх бүтээлдээ хүн ба хорвоогийн
тухай санаа бодлоо сааж хөх Монголын
өчигдөр ба өнөөдөр, маргаашийн хувь
заяаны тухай бодол эргэцүүллээ уншиг-
чидтайгаа хуваалцжээ. Эл найраглалыг
уншихад яагаад ч юм надад эрдэнийн
зуун найман эрхийг эргүүлж байх шиг
санагдав.

Хүйлэн хөх хязгааргүйд

Хөвж яваа аянчин юм билээ бид
Хөрст алтан дэлхий
Хөсөглөж яваа унаа маань юм билээ

хэмээн нүдэнд харагдаж, сэтгэлд уягд-
тал яруухнаар дүрслэн үзүүлээд эх
дэлхийгээ эх оронтойгоо буюу хүлгийн
шинжтэй дархан уул Хөх морьт
хайрхантайгаа холбож

Хэвлэг Алтайн энэ хөх уул
Хөх морьт нэртэй хорвоод ганцхан уул
Ураг удмын голомтны гал уул
Уянга дуудсан сэтгэлийн зул уул
Шүлгэн хөшөө босгоё уу гэж
Сүслэн санаж мөргөө үү гэж
Билгийн хурдыг сойлоо, би
Бэхэн зэлээ татлаа, би гэжээ.

Найраглалыхаа бадаг бүрийн утгыг
улам тодотгож

Хөх совин татна
Хөх шувуу жиргэнэ гэх буюу эсвэл
Хөх цадиг хөвөрнө
Хөсөг тэрэг цуварна

гэх зэргээр шаглан урлажээ. Эдгээр хоёр
мөртүүдэд найраглалын амин сүнс зан-
гидагдсан байна.

Уртын дуу уянгална
Урьд нас эргэж ирнэ гэх буюу эсвэл
Хөх шаштир хүүрнэнэ
Хөлгөн хуур хүнгэнэнэ гэх зэргээр
үргэлжлүүлжээ.
Сүг зураг амилна
Сүнс нийлж дарвина гэж
сүлжилдүүлэн холбож жирэмлээд
Хөх туг дэрвэнэ
Хөө хуяг шаргина

гэх зэргээр шаглаж эмжээрдсэн байна.
Эдгээр дахилт давталтуудыг нийлүүлээд
найраглалын тав дахь хэсгийг амилуулж
бүрдүүлсэн байх жишээтэй ажээ. Энэ
бол шинэ эрэл, шинэ арга мөн. "Хүйлэн
хөх замилан" найраглалд

Хүйлэн хөх замиланд
Хөх Монгол хөвж явна

Хүний энэ орчлонд
Хөх толбоо тээж явна гэх буюу эсвэл
Хүйлэн хөх замиланд
Хөх Монгол нүүж явна
Хүний энэ орчлонд
Монголын заяа гийж л явна

гэсэн тансаг мөр бадгууд шүр, сувд шиг
гялтганан гялалзах нь урамс сэргээх
ажээ.

Хөх Монголын хөдөөд
Хөх чоно улина
Хөх тэнгэрт гомдоллон
Уйлж байх шиг санагдана
Дэлхийд зартай хөх чоно
Дээдсийн сүнсийг дуудаад
Дээлтэй түмний омгийг огшоож
Дуудаж байгаа нь ч тэр юм уу
Холын холоос
Хоёр морьтон наашилна
Хонин дотор
Хос тогоруу явгална

хэмээн гүн ухааны бодол эргэцүүлээр
уг найраглалыг урлан зангидаж төгсгө-
жээ. Эл найраглал бичлэгийн өнгө
аясаараа өөр боловчиг агуулгын далайц
хийгээд ур хийцээрээ дорнын их яруу
найрагч Бэгзийн Явуухулангийн "Би
хаана төрөө вэ?" хэмээх алдарт найраг-
лалыг эрхгүй санагдуулж байна.

Номонд өөр олон тансаг сайхан
шүлэг, найраглал оржээ. Тэр бүгдийг
шинжлэн задалж ярих боломжгүй ч ганц
нэгийг ч болохноо сугалан авч уншигч
таны анхааралд өртүүлэн өгүүлэхийг
хичээлээ.

Орой боллоо
Одод түглээ
Совин татлаа
Солир харвалаа
Аав минь намайг тэндээс
Алгадаад авах шиг боллоо
Ай хөөрхий би гэдэг хүн
Алдаж л яваа юм болов уу даа гээд
түүнийгээ түүчэйлэн залгуулж

Урь уналаа
Хур буулаа
Совин төрлөө
Солонго татлаа
Ээж минь намайг тэндээс
Илээд авах шиг боллоо
Ээ хөөрхий би гэдэг хүн
Болж л яваа юм болов уу даа

гэсэн нь хэн хүнд ухаарал бодрол
төрүүлнэ гэдэгт эргэлзэхгүй байна. “Ач
минь-амь минь” хэмээх сэтгэлийн
дуулал шүлэгтээ:

Ач минь, ач минь, амь минь
Алдрайхан жаахан агь минь
Алтан ургийн бичээсээс нэр нэхэж
төрлөө
Авах, өгөхийн хорвоогоос өр нэхэж
төрлөө
Аху наран ертөнцөөс зай нэхэж төрлөө
Айраг юмсан бол би
Ааг нь ханаж шуугилаа
Алим юмсан бол би
Амт нь гүйцэж нуугилаа
Аялгуу юмсан бол би
Айзам яруусч дуурслаа
Алт юмсан бол би
Илт тунарч шижиртлээ
Ач минь, ач минь, амь минь
Анхил нялхын ааш минь
Аав, ээж хоёртоо ухаан нэмж ирлээ
Алтай, Хангай хоёртоо мөр нэмж ирлээ
Алдар түүхт Монголдоо бүл нэмж ирлээ

Тэнгэр юмсан бол би
Хураар ивлэж зүсэрлээ
Тэнгис юмсан бол би
Хурай түрж сүжирлээ
Газар юмсан бол би
Намар нялхарч дэлгэрлээ
Гариг юмсан бол би
Солонго наадуулж эргэлдлээ
Үр минь, үр минь, дүр минь
Өөдсөн чинээ хүү минь
Өд сөдийг чинь тэгширтэл
Өвөр нөмөртөө багтаая
Үүрээ орхиод нисэхэд чинь
Үүдээ нээгээд хүлээе
Үүрд буцсан хойноо
Үрдээ эргэж төрөө дөө

гэсэн нь үнэхээр амьд, үнэмшилтэй
яруухан, бас уяралтай сонсогдож байна.
Ач зээгээ үзсэн өвөө, эмээ нар бүгд л
ингэж хэлнэ дээ. Дагвын Цахилгаан
түүнийг нь даанч сайхнаар шүлэглэн
буулгажээ. Хүйлэн хөх орчлонд хүн болж
төрсний учир утга, үр үндсээ үлдээж
үржиж төлжих үүрдийн хүслийн учиг утга
чухам үүнд оршном бизээ.

Тэрбээр бас зээдээ зориулж “Нин-
жүүлээ” хэмээх хөөрхөн шүлэг туурви-
жээ.

Нинжүүлээ дээ, минжүүлээ
Миний муухай гүнжүүлээ
Үнсүүлээч дээ, үнсүүлээч
Үнгэлэн даахьтай сонжуулай
Нинжүүлээ дээ, минжүүлээ
Ижий, аавдаа инжүүлээ
Үнсүүлээч дээ, үнсүүлээч
Өөдсөн чинээ мөндүүлээ

хэмээсэн нь нэн уянгалаг бөгөөд хөг-
жимлөг, өлгийн бүүвэйн дуу шиг хайр
энэрэлээр нэвт бялхаж байнам бус уу?

Зохиогч “Хөх мөрөн” хэмээх түүхчил-
сэн найраглалынхаа “Бүх нийтийн санал
асуулга” хэмээх хэсэгт Монголын ард
түмэн тэртээх 1945 оны 5-р сарын 20-нд
тусгаар тогтнолынхоо төлөө нэгэн дуу-
гаар саналаа өгч бүх нийтээр тусгаар
тогтнолоо хамгаалан бататгаж магнай
тэнийн баярлаж догдолсон гэрэлт
мөчийг

Тэр өдөр наран саран хоёр тохиож
хоносон
Тэр шөнө тэнгэрийн одод бүжиглэж
хоносон
Тэр цагт Монголын бүх хаадын сүнс
баясан чуулсан
Тэр үед Монгол хүн бүр эх орныхоо
төлөө
Өрцөө ярж зүрхээ сугалж өгөхөд
бэлэн байсан

хэмээн илэрхийлжээ. Зохиогчид Монголын өчигдөр, өнөөдөр, бас маргааш бүгд хамаатай болохоор тэрбээр “Их ажлын нүргээн” шүлэгтээ

Үе солигдож, үзэл бодол холилдож
Үндэс угсаа ялгарч, өрсөлдөж
уралдаж байхад
Үгээр хийрхэж, өвөр зуураа
хэмхэлдсээр
Үнэндээ бид юу хожив, юу бүтээв?

хэмээн чанга дуугаар асуужээ. Энэ шүлгийг БНХАУ-д Элчин сайдаар ажиллаж байхдаа бичсэн бололтой. Миний бие сүүлийн 7-8 жил Хятадад зорчилгүй байж байгаад саяхан нэг очихдоо яг ийм сэтгэгдэл төрсөн. Тэр тухай сэтгэгдлээ уншигчидтайгаа хуваалцах, зөвлөлдөх зорилгоор “Аварга хүчирхэг луун архи-ран хүрхрэн айсуу” хэмээх аян замын тэмдэглэл бичиж “МОНЦАМЭ мэдээ” сонины 2009 оны №212 (1814)-д нийтлүүлсэн билээ. Уг нь хүн бүр л ийм бодол санаатай байвал улс эх оронд минь хэрэгтэйсэн дээ. Хүн харьд аялаж юм үзэж нүд тайлахын хэрээр ухааных нь далай улам тэлж эх орноо хайрлах сэтгэл нь дүрэлзэн асдаг билээ. Д.Цахилгааны олон шүлгээс энэ санаа нэвт гэрэлтэж байна. Жишээ нь “Хавайн бороо” шүлэгтээ:

Хавайн бороо, хачин бороо
Хаанаас ч юм нэг л мэдэхэд
Харагдах үүлгүй тэнгэрээс
Баригдах биегүй мяндас шиг намирч орно
Номхон цагаан бороо
Ногоон арлаа ноолж орно
Номин далайгаа таалж орно
Ноён уулаа тойлж орно
Хөтлөөд явж болдогсон бол энэ бороог
Хөдөө талдаа аваачих юмсан
Хөмүүл таана нь ургана даа

Хүмүүн, мал нь жаргана даа
Таслаад явж болдогсон бол энэ далайг
Тал говьдоо аваачих юмсан
Тариа будаа сугсарна даа
Тансаг амьдрал дэлгэрнэ дээ гэжээ

Элэг зүрхнээс уяатай эх орон гэдэг ийм буюу. Энэ санаагаа зохиогч нэг биш шүлэг найраглалдаа уран үгээр илэрхийлэн гаргажээ. Тухайлбал “Бусдын нутаг танихгүй айл шиг” хэмээх шүлэгтээ:

Үнэр амтгүй навч цэцэгс нь
Үнэнийг нуусан тохуу шиг
Өрж сөгнөсөн архи дарс нь
Үг өдсөн доог шиг
Барагшин хайлдсан дээр
Хаймран хээ эржийнэ
Судар нь тэр юм шиг
Барьцаа, хувьцааны зөрөөн дээр
Баян, хоосон арсалдана
Авир нь тэр юм шиг
Буугаад мордоход буруугүй ч
Бусдын нутаг танихгүй айл шиг

гэсэн бол өөр нэг шүлэгтээ:

Нэрийг нь мэдэхгүй бүсгүй
Нисэх буудалд тослоо
Нэг л их том
Мэлмэн хар нүд...
Нэрлэж мэдэхгүй цэцгийг
Надад өргөн барилаа
Нэг л их том
Нэлмэн цагаан дэлбээ...
Үнэрч үгүй тэр үзэсгэлэнгээс
Өргөс хатгахыг мэдэрлээ...
Нэг л их том мэлмэн хар нүд
Нэг л их том нэлмэн цагаан дэлбээ... гэжээ.

“Балбад очсон шөнө” хэмээх өөр нэг шүлэгтээ:

Балбад очсон тэр шөнө
Байн байн нохой хуцаад
Багын ахуй, талын айл
Малын хэвтэр бодогдоод
Бадамдуламын барьсан сархад
Баахан хэтрэв үү, толгойд гараад
Бараг мартсан юм зүүдэнд хувилж

Дэрэн завсар шурган хургаад...

хэмээн мөн л эх нутаг, элгэн садантай-
гаа холбож, нээрээ л тэгдэг дээ гэж бо-
догдтол уран яруухнаар дүрсэлжээ.

Хорвоо чи надад
Өөрийн гэх зай хайрла
Хоёр амь багтах
Халуун дулаан үүр хайрла
Үүнийг л бүү харамла
Өөр бусдыг нь
Өөрөө би олно оо

Хорвоо чи надад
Эвлэсэн сэтгэлийн илч хайрла
Хоёр биеийг эрхшээх
Ивлэсэн зүрхний эрч хайрла
Үүнийг л бүү харамла
Өөр бусдыг нь
Өөрөө би олно оо

Хорвоо чи надад
Нар, хур шиг урам хайрла
Нас, зүс залгах
Навч цэцэг шиг удам хайрла
Үүнийг л бүү харамла
Өөр бусдыг нь
Өөрөө би олно оо

хэмээн эрхэмсэг омгорхоогоор "Хорвоо
чи" хэмээх шүлэгтээ шүлэглэсэн авьяас-
лаг яруу найрагч Дагвын Цахилгаан ном
нээх үгээ "Урам" хэмээн гарчиглаад "Огт
оргуйн толь" анхны ном минь олон
шүүмж, сэтгэгдэл, захидал дагуулж их
урам өглөө...

Урмаар тэжээгдэж "Бат хаан",
"Доголон төмөр", "Морьтынхон" гээд
түүх, уран сайхны нийтлэлийн номууд
гаргасанд минь эрдэмтэн, судлаач,
уншигчид ам сайтай байгаа нь бас л
урам. Цаашид би энэ чиглэлээр голлон
ажиллах бодолтой" гэжээ. Их зөв бодол,
их зөв чиглэл гэж нэрлэлтэй.

* * *

Монгол Улсын Хөдөлмөрийн баатар,
Ардын уран зохиолч Лодонгийн

Түдэвийн толгойлсон "Хаадын ном"
бүтээлийн зөвлөлийнхөн профессор
Нямжавын Дугарсүрэнгийн эрхлэн
эмхэтгэж эхлүүлснээр Монголын 100
хаан, найман Богдын тухай 108 цуврал
хэвлүүлж байгаа билээ. Тэрхүү 108
бүтийн 32 дахь ботийг доктор Дагвын
Цахилгаан 2003 онд дагнан туурвиж
нийтийн хүртээл болгосон юм. "Бат хаан"
хэмээх энэхүү нийтлэлийн томоохон
бүтээл нь 9 бүлэгтэй бөгөөд нийт 47 дэд
гарчгаас бүрдэж байна. Монголын их
хаадын түүхэнд өөрийн гэсэн өвөрмөц
хүндтэй байрыг эзэлсэн Бат хааны
амьдрал, үйл ажиллагааны талаарх
нарийн ширийнийг дотоод, гадаадын
эрдэмтэн судлаачдын олон арван
бүтээл, эх сурвалжийг үндэслэн үнэн
мөнөөр нь товойлгон гаргасан бараг
анхны танин мэдэхүйн хялбарчилсан
нийтлэлийн чамбай бүтээл болсон гэж
хэлж болно. Зохиогч найман зууны
тэртээд болж өнгөрсөн үйл явдалд
хандахдаа түүхэн үнэнийг ягштал
баримталж, түүнийг уран сайхны аргаар,
нийтлэлийн хэл хэллэгээр дүрслэн
үзүүлэхийг эрмэлзсэн нь оносон байна.

Чингис хааны итгэлт сайн нөхөр
домогт жанжин Сүбээдэй хорин
наймхан настай залуухан Бат
хааны дэргэд бат багана, түшиг тулгуур
нь болж зөвлөж их үйлсэд хүргэснийг,
Зүчи хаан хүүдээ Монголын эзэнт гүрний
бат бэхийг бэлгэдэж Бат хэмээх нэр
хайрласныг, өвөг Чингисийн эзэнт
гүрний хил хязгаарыг өргөжүүлэн тэлэх
их үйлсэд Бат хаантай Өгөөдэйн Гүюг,
Хадаан, Тулуйн Мөнх, Цагаадайн
Байдар, Бури зэрэг найман хан хүү хамт
байлдаж явсныг, тэднээс хоёр нь сүүлд

их Монголын хаан ширээнд заларсныг, Зүчийн удмын 38 монгол хаан Алтан ордны улсын жолоог 250 гаруй жил, түүний дотор Бат хаан 1227-1255 он хүртэл 28 жилийн турш атгаж өргөн олон түмнээс "Сайн хаан" алдрыг хүртсэнийг уншигчид энэ номноос олж мэдэх болно.

Монголын эзэнт гүрний их хаан Өгөөдэй 1235 онд нийслэл Хархорин хотноо их хуралдай зарлан хийлгэж Орос, Европыг эрхшээлдээ оруулж алс хэтийн аюулгүй байдлаа бататгах ухаалаг шийдвэр гаргаж, түүнийг од нь гийж, аз нь шовойсон Бат хаан гүйцэлдүүлснийг "Бат хаан" номонд өргөн хүрээнд үнэмшилтэйгээр урлан гаргаж чаджээ. Бат хааны цэргийн жанжны ур чадвар, ухаалаг шийдвэр, их цэргийн доторх өндөр нэр хүнд, өгөөмөр сэтгэл зэргийг зохиогч үйл явдлын өрнөлтэй холбон дүрсэлсэн байна.

Суздалийн сурвалжит ван Ярославт хандсан Бат хааны үйлдэл, түүнийг өмгөөлөл нөмөртөө авч нөхөрлөн сүүлд Рязаний вант улсыг байлдан сөхрүүлж, Хойт Оросын нийслэл гэгдэж байсан Владимир хотыг довтлон буулгаж аваад Ярослав ванг урин авчирч Владимир-Суздалийн улсыг захиран суугчаар томилж байгаа зэрэг нь Бат хааны алсын хараа, авхаалж самбаа, дайснаа ч гэсэн өөрийн талд татаж сайн нөхөр

болгож хувиргаж чаддагийг илтгэн харуулж байна.

Рязанийг байлдан эзлэж авсны дараа Бат хаан цэргийн ноёдыг цуглуулан заавар тушаал өгөхдөө онцын шаардлагагүй бол хот сууринг бүү эвд, эсэргүүцэн тэмцэлдээгүй бол цэрэг, иргэдийг бүү ал хэмээн анхааруулж хэлж

байгаа нь ч түүний дүр төрхийг улам тодотгон гаргаж өгч байна.

Бат хааны анхны их аян дайн 1238 оны намар өндөрлөхөд тэрбээр гучхан настай, Гүюг гучин хоёр настай, Мөнх мөн гучхан настай гал дөл шиг цоролзон бадарч явжээ. 1240 оны 11-р сарын хуучдаар Мөнх, Гүюгийн толгойлж Батын манлайлсан Монго-

«

*Монголын их хаадын түүхэнд
оорийн гэсэн овормоц хүндтэй
байрыг эзэлсэн Бат хааны
амьдрал, үйл ажиллагааны
талаарх нарийн ширийнийг
дотоод, гадаадын эрдэмтэн
судлаачдын олон арван бүтээл, эх
сурвалжийг үндэслэн үнэн моноор
нь товойлгон гаргасан бараг
анхны танин мэдэхүйн
хялбарчилсан нийтлэлийн чамбай
бүтээл болсон гэж хэлж болно.*

»

лын их цэрэг Киевийг бүсэлж довтлохын өмнөхөн эсэргүүцэлгүй бууж өгвөл иргэн, цэрэг хэний боловч амь насыг өршөөнө гэсэн утгатай шаардах бичгийг хүргүүлсэн боловч тэрхүү Монгол төрийн элч хориод хүнийг хотыг хамгаалж байсан Дмитрий жанжин барьж аваад нэгээс бусдынх нь толгойг авч "үхсэн ч, сэхсэн ч үзэлцэн тэмцэлдэнэ" гэсэн хариу ирүүлсэн байна. Энэ нь зууралдан тэмцэлдсэн аймшигт тулалдааны эхлэл болсон юм. Арав хоног амсхийлгүй алалдан тулалдсаны эцэст монголчууд Киев хотыг эзлэн авч байна. Дмитрий жанжин шархдаж баригджээ. Гэвч Мөнх

түүний эрэлхэг зоригийг үнэлж суллан тавьж явуулсан тухай эл номд мөн өгүүлж байна.

Эзэн Богд Чингис хаан, түүнийг залгамжлагч Монголын хаад хүн төрөлхтний түүхэнд зөвхөн цэрэг дайны урлагийг боловсронгуй болгон хөгжүүлэхэд шийдвэрлэх түлхэц үзүүлсэн төдийгүй, улс хоорондын харилцаа, дипломатын үйл ажиллагааны эрин үеийг эхлүүлж элчин төлөөлөгчдөө эхлэн илгээж ярьж хэлэлцэх, ам хэлээ ололцохыг урьтал болгон чухалчилж байсан билээ. Харамсалтай нь өнөөгийн соёлт Европ тэр үед үүнийг мэддэггүй, бүр тоодог ч үгүй байсан тул элчүүдийг толгой дараалан хяргаж залхаадаг нь дайн байлдаан гарах нэг үндсэн шалтаг болж байжээ. Эл түүхэн үнэнийг зохиогч "Бат хаан" номондоо хөдөлшгүй түүхэн баримтад тулгуурлаж үнэмшилтэйгээр дүрслэн үзүүлсэн байна.

Монголын их цэрэг Европын элгийг цөмөлж өнөөгийн Карпатын нурууг даван Польш, Унгар, Румын, Болгарын нутаг дэвсгэрт нэвтэрч орсон хийгээд Цагаадайн ач Бажуу ноёны захирсан монгол цэрэг Кавказын өврөөр баруун зүг давшиж 1241-1243 онд Дамаск хүртэл дайтаж одоогийн Туркийг номхруулж Арменийг дагаар оруулж Гүрж, Армени, Азербайжанд засаглалыг төвхнүүлж байсан тухай өргөн их үйл явдал "Бат хаан" номонд тусгалаа олжээ. 1230 онд Өгөөдэй хааны зарлигаар Чормаган хорчи цэрэг авч Персийг дарахаар мордсон тухай, 1231 онд Желал ад-Дины цэргүүдтэй тулалдан Багдадыг дайлаар аваад захирагчаар суусан тухай ч мөн орхилгүй өгүүлжээ.

Зохиолч өөрийн номондоо Ярослав ванг бүх Оросын их вангаар Бат хаан томилсон тухай маш сонирхолтойгоор өгүүлсэн байна. Бат хаан, Ярослав ван хоёрыг ямар эрх ашиг нэгтгэж байв гэж асуугаад: *нэгд*, Монголын хаант улсын илэрхий хүчирхэг байдал, цэрэг зэвсгийн давуу тал Оросын дээдэс, сурвалжит хүмүүсийг болгоомжит байр сууринд тавьж, аясыг дагах бодлого барихаас өөр аргагүйд хүргэсэн; *хоёрт*, тэр үеийн Орос орон Европын өрнө, умраас ямагт шахалт дарамтад өртөж Герман, Польш, Литва, Шведийн цэрэглэсэн довтолгоо тасрахгүй байсан; *гуравт*, Батын цэрэг Оросын дараа Европыг дайлах нь бүр анхнаасаа тодорхой байсан тул оросууд монголчуудын гараар могой бариулж дайснаа даруулж авах далд зорилго агуулсан гэж хариулсан нь түүхэн үнэн, тухайн үеийн бодит байдалд таарч нийцсэн хариулт, үнэн зөв үнэлэлт дүгнэлт, гаргалгаа болжээ гэж үзэх бүрэн үндэслэлтэй байна.

"Ийнхүү Европыг дайлах асуудал дээр тухайн цагт Орос, Монгол хоёрын ашиг сонирхол таарч байжээ. Чухам энэ өнцгөөс Бат хаан, Ярослав ван хоёрын эвтэй байсныг тайлбарлаж болно. Товчдоо бол тэр хоёр хэн хэндээ хэрэгтэй байжээ"² хэмээн зохиогч бичсэн байна. Зохиогч мөн энэ хэсэгт Бат хаан Ярослав вангийн хүү Александрийг дэргэдээ авч өөрийн хүү Сартагтай хүж бариулан ах дүү болгосон тухай, энэ нь Бат хаан, Ярослав ван хоёр бие биедээ итгэж, эвтэй найртай явахын бэлэгдэл болж байсан талаар өгүүлжээ. "Ер нь ураг барилдах "дипломат" аргыг Монголын хаад дээр үеэс их чадмаг хэрэглэдэг

байжээ”³. Энэ бол Ярослав ванг бүрэн итгэтлээ хүүг нь хажуудаа байлгаж барьцаа чангалж байх нь дээр гэж үзсэнийх билээ гэсэн бодит дүгнэлт хийсэн байна.

Монгол, орос хоёр жаал үерхэн нөхөрлөж, түргэн хугацаанд ойртон дотноссон байна. Ярослав вангийн энэ хүү хожмын өдөр “Невийн Александр” хэмээн алдаршсан домогт жанжин, төрийн зүтгэлтэн болсон бөгөөд түүхэнд зарим судлаачид түүнийг Бат хааны өргөмөл хүү гэж бичиж ирсэн нь бодит үнэн юм. Харамсалтай нь үүнийг Оросод ч, Монголд ч тэр бүр олон хүн мэддэггүй юм.

Бат хаан өөрийн улсын аюулгүй байдлыг ханган хязгаар нутгийг бэхжүүлэх, зэвсэг техник хийж залуу цэрэг эрсийн байлдах чадварыг байнгын бэлэн байдалд байлгах, жирийн хүмүүсийн аж амьдралд анхаарч, шашин шүтлэг, зан заншил, хэл соёлыг нь хүндэтгэх, нөлөө бүхий ихэс дээдсийг өөрийн талд татаж, итгэлт хүмүүсээ болгох талаар, өөрөөр хэлбэл 1242 онд түр зуур мориноосоо бууж улс гэрээ товхинуулах талаар их зүйл хийснийг, энэ нь мориноосоо буулгүйгээр дэлхийн талыг эзлэхээс хүнд хэцүү байсныг номонд үнэн мөнөөр нь өгүүлсэн байна. Бат хаан бол цэргийн гарамгай жанжин, нийгмийн аж төрөх ёсыг шинэчлэгч (суурьшил төвлөрлийг бий болгож үйлдвэрлэл, гар урлал, худалдаа арилжааг хөгжүүлэн, газар тариаланг хөхиүлэн дэмжсэн г. м.), улс хоорондын харилцаанд дипломат ёсыг нэвтрүүлэгч (Гүрж рүү элч зарж эвийн аргаар хэл амаа ололцож чадсан, Рум, Сири зэрэг улсын султан нарт худал-

дааны хөнгөлөлтийн бичиг, пайз шийтгэн олгож, үнэнчээр зүтгэгчдэд шан харамж олгож байсан зэрэг) байсныг зохиогч өөрийн номондоо түүхэн жишээ баримтаар батлан үзүүлсэн байна.

Бат хаан бол хэдийгээр хүчирхэг нэгэн байсан ч хүмүүн биеийг олж төрсөн амьд бодьгал юм болохоор жаргал, зовлонгийн дундуур туулж, дотоодын зөрчил тэмцлийг давж зохицуулж гарсныг зохиолч орхигдуулсангүй. Энэ тухай “Их хаангүй ээдрээт жилүүд”, “Бат, Гүюг хоёр”, “Мөнхийг их хаанд суулгав” зэрэг бүлэгт тодорхой дэлгэн үзүүлсэн байна. Өгөөдэй хаан нас барж, түүний бэр Дөргэнэ хатны эрх мэдэл гаарч, Алтан ургийнхны дунд хаан ширээний төлөөх тэмцэл хурцадсан хийгээд харь гүрнийхний хатгаас түлхээсээр бусармаг үйлдэл ихсэж түүнд нь Дөргэнэ автагдах болсон тухай гарч байна. Түүний итгэлт баруун, зүүн гараар харийн тагнуулч Фатима, Абдурахман хэмээх хоёр хутган үймүүлэгч тодорсон аж. Хархорумд тэр гурвын үгээс зөрөх нь битгий хэл өөдөөс нь эгц харж чадах зоригтон хүнгүй болсон байна. Энэ нь улс гэр үймж эхлэхэд хүргэжээ. Бат хаан ихэд шаналан зовж байсан тул хаан ширээний төлөөх тэмцэлд төвийг сахих, явц байдлыг харзнах байр суурь баримталж байжээ. Дөргэнэ хатны хорсол, Алтан ургийнхны тэмцэл дунд Гүюг их хааны суудалд тунаж үлдсэн байна. Энэ нь тухайн цаг үед түүний эх Дөргэнэ хатны дарангуйлал ба бурангуйллаас гарз багатай гарах цорын ганц арга байсан аж. Дөргэнэ хатан, түүний хүү Гүюг нартай таарч тохирдоггүй, дотроо Гүюгийг голж

байсан Бат хөл өвчтэй нэрээр Их хуралдайд эхлээд очоогүй байна. Ахин дахин гуйлгасны эцэст дүү Бэрх, хүү Сартаг нарыг, бас их ван Ярославыг Хархорум руу илгээжээ. Хоёр хүү нь Ярославыг даган явсан гэнэ. "Биеэ илааршах"-аар чадвал араас нь очно гэж Бат хаан хэлүүлсэн байна. Хархорумд Их хуралдайн өмнөхөн Оросын их ван Ярослав учир битүүлгээр хорлогдож, Ромын папын элч төлөөлөгч-тагнуулч лам Плано Карпини энэ тухай их цуурхал тарааж, Гүюг Монголын их хаанд өргөмжлөгдөж, улмаар эх Дөргэнэ хатны зарим үйлдлийг хязгаарлан залруулж, Бат ба Гүюг хааны их цэргүүд сөргөлдөн тулалдаж алагдахын ирмэг дээр Гүюг хаан нас барсан зэрэг олон сонирхолтой үйл явдал ар араасаа өрнөн гарч байна. Ярославын хоёр хүү Батын талд баттай орсон тухай ч өгүүлжээ.

Номын 7 дугаар бүлэгт Мөнхийг Монголын их хаанд суулгасан тухай, 8 дугаар бүлэгт 1251-1255 оны үйл явдлыг хураангуйлж, 9 дүгээр бүлэгт Батын дараа үеийн Монголын их эзэнт гүрний тухай тус тус өгүүлсэн байна.

Эрдэмтэн зохиолч Д.Цахилгаан өөрийн бичсэн "Бат хаан" номынхоо эцэст уг түүхэн үйл явдалд хандах өөрийн хандлагыг "Учиг үг буюу төгсгөл" хэсэгтээ түүхийн шинжлэх ухааны үүднээс нотлон илэрхийлсэн нь маш чухал зүйл болсон гэж бодож байна. Үйл явдлыг өргөн хүрээнд товойлгон үзүүлж, хөдөлшгүй түүхэн баримтад тулгуурласны үндсэн дээр "Бат бол өөрийн алдарт өвөө Чингис хааныг амьд сэрүүнд нь

авшиг хүртэж, эцэг Зүчийн эзэмшил нутгийг өвлөн захирах зарлиг хүлээсэн гойдын заяат түүхэн бодьгал агаад Өгөөдэй, Гүюг, Мөнх гурван их хааны үед Монголын эзэнт гүрний баруун гарын Алтан ордны улсыг эрхшээн захирч явсан цуут хаан бөлгөө"⁴ гэсэн зөв дүгнэлтийг хийсэн байна.

Зохиолч өөрийн бүтээлдээ зөвхөн Бат хааны хувийн аж амьдралыг өгүүлэх зорилт тавьсангүй, тухайн үеийн Монголын нийгмийн амьдрал, хөрш зэргэлдээх улс гүрнүүдийн дотоод, гадаад нөхцөл байдалтай уялдуулан холбож авч үзсэн нь оносон байна. Үүний тодорхой жишээ нь "Бат хаан, түүнийг залгамжлагчид, ер нь Алтан ордны улсын түүх бүхэлдээ нэг талаас Монголын, нөгөө талаас Оросын түүхэнд томоохон байр суур эзлэх бөгөөд Монгол, Оросын харилцааны эртний үе, хэдэн зууны ээдрээт үйл явдлыг судлах шинжлэх, дүгнэх цэгнэхэд барин тавин холбогдож байгаагаараа онцгой үнэтэй юм"⁵ гэсэн зохиолчийн дүгнэлт болой.

Уншигчдад сонирхуулж хэлэхэд "орос хүнийг сайн тэмтэрвэл татаар яс баригдана" гэсэн хэлц үг байдаг. Үнэхээр ч монголчууд Оросын түүхэнд арилж баларшгүй ул мөр үлдээсэн нь үнэн юм. Зарим судлаач, түүхчдийн бүтээлээс үзвэл Монголын удмаас Оросын хаан Догшин Иван, Борис Годунов нар тодрон гарсан байдаг. Их Петрийн эх Наталья Нарышкина ч мөн адил Монгол угсааных. Их эрдэмтэн Менделеев, Мечников, Павлов, Тимирязев, нэрт түүхч Кантемир, Карамзин, Л.Гумилёв нарын удам угсаа нь Монголоос гаралтай. Гайхамшигт зохиолч Достоевский, Тургенев,

Державин, Куприн, Булгаков, алдарт балетчин Галина Уланова, Анна Павлова, их зураач Шишкин зэрэг цөөнгүй хүний судсаар монгол цус гүйж⁶ байжээ. Энэ тухайг уншигч та эл бүтээлээс үзэж болно.

“Батын үйл амьдрал бол нэг талаасаа дайн байлдаан, нөгөө талаасаа бүтээн байгуулалтын түүх юм”⁷ гэсэн даацтай дүгнэлтийг Д.Цахилгаан өөрийн номонд хийжээ. Үүнтэй эрүүл саруулаар сэтгэгч олон түүхч, судлаач санал нэгдэх буй заа. Зохиогч Бат хааны эзэгнэн төрсөн цаг хугацаа, орон зай, наран ургах их далайгаас наран шингэх их далай хүртэлх тэлж өргөжсөн, түүхэнд дахин давтагдашгүй түүний гүрэн улсыг шинжиж судлаад “Чингис, Өгөөдэйн үеэс үүсч бүрэлдсэн Монголын эзэнт гүрэн, мөхөс миний төсөөлснөөр бол, Холбооны (Federation) бүтэцтэй байжээ”⁸ хэмээн зөв зүйтэй тодорхойлсон байна.

Бас “Монголын эзэнт гүрэн” хүчирхэгжиж, түүхэнд урьд хожид байгаагүй дэлхийн талыг эзэлсэн аварга их улс байгуулсан нь угаасаа феномен шинжтэй, онцгой үзэгдэл юм”⁹ гэсэн сонирхолтой дүгнэлт хийжээ. Уг үйл явдал нь өөрөө феномен шинжтэй учраас түүний эхлэл өрнөл, оргил туйл, гандан бууралт, тэдгээрийн учир шалтгааны учиг холбоосыг онол сэтгэлгээний

хэвшэл ойлголт, “нийтлэг зүй тогтол”-ын үүднээс тайлбарлах аргагүй. Онцгой зүйл нь онцгой нөхцөл орчинд, онцгой цаг үед, онцгой орон зайд л бий болсон байж таарна гэж зохиогч өөрийн таамаглал, санал бодлыг илэрхийлсэн байна.

Бат хаан бол Монголын бусад хаадын

нэгэн адил “Тэнгэрийн үзэл”-тэй хүн байсан. Түүний үйл ажиллагаанд өнөөгийн даяарчлах буюу дэлхийчлэх үйл явцын зарим шинж тэмдэг ажиглагдаж байна гэж Д.Цахилгаан номондоо онцлон тэмдэглэсэн нь бодит үнэнтэй нийцэж байна. Их эзэн Богд Чингис, түүнийг залгамжлагч Монго-

«

Маш товчоор хураангуйлан өгүүлбэл зохиолч, нийтлэлч Д.Цахилгаан “Бат хаан”, “Доголон Төмөр” түүхэн нийтлэлийн хоёр ч ном туурвиж Монголын “Хаадын ном”-ын санд хандивлан өргөснөөрөө өнөө, маргаашийн монгол уншигчдын хувьд эх түүхээ үнэн зөвөөр нь үнэлж ухаарах ихээхэн чухал ариун үйлсийг бүтээж, өөрийгөө их түүхийн эрмүүн улаачийн нэг гэдгээ гялалзтал нотлон харуулсан юм.

»

лын хаад өрнө дорныг холбосон чөлөөт худалдаа арилжаа, чөлөөт харилцаа холбоог түгээн дэлгэрүүлж, улс гүрнүүдийн хооронд дипломат харилцааны цоо шинэ дэг жаягийг нэвтрүүлэн тогтооход үнэлж баршгүй түүхэн үүрэг гүйцэтгэсэн билээ. Үүнийг ганцхан бид нар хэлж байгаа юм биш. Олон улс орны цөөнгүй эрдэмтэн мэргэд ингэж үзэж баталж нотолсон байдаг. “Бат хаан” номыг бүтээгч тэдгээр түүхчид, судлаач эрдэмтдийн зохиол бүтээлээс өөрийн номонд өргөн дэлгэрээр авч ашигласан нь бүтээлийн үнэ цэнэ, үнэмшлийг улам

өндөрт өргөж өгсөн болохыг сайшаан тэмдэглүүштэй.

“Вашингтон пост” сонин, “Таймс” сэтгүүл Чингис хааныг мянган жилийн сод хүнээр тодруулан зарласан том өгүүлэлдээ XIII-XIV зууны Монголын эзэнт гүрний нээлттэй бодлого, хурд, эрч хүч, дэг журам, мэдээлэл, харилцааны шуурхай, түгээмэл тогтолцоо, итгэлцлийг чухалчилдаг үзэл өнөөгийн хөгжингүй орнууд, ялангуяа Америкийн бодит байдалд тусгалаа олж байгааг товойлгон тэмдэглэсэн бий. “Америк бол эрин үеийн Чингисийн эзэнт гүрэн” гэж Солонгосын монголч эрдэмтэн бичжээ”¹⁰ гэсэн байна. Энэ бол үнэн билээ.

Л.Н Гумилёв бичихдээ: “Монголчуудын хийсэн аян дайн ... хамгаалах дайн байжээ” гээд “Монголчуудыг цаг ямагт хатгаж, өдөж, хамгаалахаас аргагүйд хүргэж байв. Тиймээс тэд хариуг нь хатуухан өгч чухам ингэснээрээ ялж дийлж байжээ” гэсэн сонирхолтой гаргалгаа хийсэн байна. XIII-XIV зууны монголчууд байлдах дуртайдаа биш, харин Монгол Улсынхаа бүрэн бүтэн, биеэ даасан байдлыг аварч үлдэх гэсэндээ, хил хязгаарын амгалан тайвныг хамгаалах гэсэндээ зогсолтгүй их аян дайнд өөрийн эрхүй татагдан орж байжээ гэдгийг энэ номноос үзэж болохоор байна. Өөрөөр хэлбэл тэр цагийн байдалд авч үзвэл “Байлдах уу, үгүй юү” гэдэг нь “Орших уу, эс орших уу” гэдэгтэй агаар нэгэн байсан ажгуу”¹¹ гэсэн үнэтэй дүгнэлтийг зохиогч хийжээ. “Чингис хааны байлдан дагуулал нь дундад зууны үед гарч байсан дайн байлдааны ердийн хэм хэмжээнд явагдаж байсан, бусдаас илүү харгис,

ширүүн байгаагүй” хэмээн Жавахарлал Неру “Ертөнцийн түүхийг сөхөж үзвэл” номондоо тэмдэглэснийг ч иш татжээ.

“Хэрэв түүхийн эх сурвалжуудыг анхааралтай шинжлэн судалбал Монголын Чингис хаан цус урсгах, харгислах, эвдлэн сүйтгэх гэж улайрч байгаагүй. Чингис тухайн эрин үеийнхээ үр хөврөл байсан, тэгэхлээр түүнийг эрин зууны нь орчин нөхцөлд авч үзвэл зохино. Түүнээс биш өөр цаг хугацааны, өөр улс орны хэмжүүрээр цэгнэх нь үл зохилдоно. Чингис хаан өөрийн хийсэн том аян дайны явцад тухайн эрин үе дэх бусад байлдаанаас илүү харгис хэрцгий явдал хийж байгаагүй” гэж үзсэн Оросын эрдэмтэн Владимирцовын үнэлэлт дүгнэлтийг ч зохиогч мөн иш үндэс болгосон байна.

Маш товчоор хураангуйлан өгүүлбэл зохиолч, нийтлэлч Д.Цахилгаан “Бат хаан”, “Доглон Төмөр” түүхэн нийтлэлийн хоёр ч ном туурвиж Монголын “Хаадын ном”-ын санд хандивлан өргөснөөрөө өнөө, маргаашийн монгол уншигчдын хувьд эх түүхээ үнэн зөвөөр нь үнэлж ухаарах ихээхэн чухал ариун үйлсийг бүтээж, өөрийгөө их түүхийн эрмүүн улаачийн нэг гэдгээ гялалзтал нотлон харуулсан юм. Үүнд нь та бид баярлаж талархах учиртай. Тэр бол бас эх орон, монгол нутаг, алт шиг үнэтэй газар шороогоо магтан дуулагч хөвгүүн мөн. Үүний хамгийн тод илэрхийлэл нь “Огт оргуйн толь”, “Хүйлэн хөх замилан” хэмээх тансагхан нийтлэл, тууж өгүүллэг, яруу найргийн хоёр чамбай ном юм гэдгийг нэмж хэлье.

Ишлэл

¹ Ц а х и л г а а н Д. 2009. Хүйлэн хөх замилан. УБ., 4 дэх тал.

² Ц а х и л г а а н Д. 2003. Бат хаан. УБ., 114 дэх тал.

³ Мөн тэнд, 114 дэх тал.

⁴ Мөн тэнд, 243-244 дэх тал.

⁵ Мөн тэнд, 244-245 дахь тал.

⁶ Мөн тэнд, 252 дахь тал.

⁷ Мөн тэнд, 247 дахь тал.

⁸ Мөн тэнд, 249 дэх тал.

⁹ Мөн тэнд, 252-253 дахь тал.

¹⁰ Мөн тэнд, 255 дахь тал.

¹¹ Мөн тэнд, 259-260 дахь тал.

Резюме

Настоящая рецензия посвящена творчеству знаменитого монгольского общест-

венного деятеля, поэта и историка Д.Цахилгаана.

Сборник его стихотворений "Хүйлэн хөх замилан" ("Вечно синее небо"), по мнению автора, является замечательным образцом лирики, а серьёзный исторический труд "Бат хаан" ("Бату-хан") – многогранным исследованием, пролившим свет на до сих пор недостаточно изученную тему. На основании многочисленных исторических источников и трудов, Д.Цахилгаан раскрывает во всей красе весь административный и полководческий гений монгольского хана, одного из самых одарённых внуков Чингис-хана.

Особенностью стиля повествования Д.Цахилгаана являются меткость высказывания, точность сравнения, простота, ясность и мелодичность изложения.